

## ХОЁР. “ҮДИЙН ЦАЙ” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

2020.12.14

2019-2020 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр “**Үдийн цай**” хөтөлбөрт 1-5 дугаар ангийн 10676 сурагч хамрагдахаар төсөвлөгдөн 2020 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн үдийн цайгаар үйлчилж байсан боловч 2020 оны 01 сарын 27-оос эхлэн Засгийн газрын шийдвэрийн дагуу Ковид-19 цар тахлын өвчлөлтэй холбоотойгоор хөл хорио тогтоосны улмаас Сангийн яам бүх төсвийг татан төвлөрүүлж хөтөлбөрийн хэрэгжилт түр хугацаагаар тасалдаж, 2020-2021 оны хичээлийн жил эхлэхэд “**Үдийн цай хөтөлбөр**” үргэлжлэн хэрэгжиж 34 сургуулийн 10832 сурагч үдийн цайнд хамрагдах болсон.

Энэ хичээлийн жилээс эхлэн “**Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай**” хуулийг мөрдөж ажиллах, Монгол улсын засгийн газрын “**Хоолны зардлын норматив тогтоох тухай**” 450 дугаар тогтоолоор “**Үдийн цай**”-ны нэг хүүхдэд ногдох хоолны мөнгө 600 байсанг 900 төгрөг болгосныг хэрэгжүүлэн чанартай хоол хүнсээр үйлчлэх шаардлагатай болсон. Мөн хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан “**Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөр**” батлагдаж, хуулийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болж байна.

Нэг хүүхдэд ногдох хоолны мөнгө нэмэгдэж, дээрх эрх зүйн баримт бичгийг хэрэгжүүлж эхлэх ажлын хүрээнд 2020-2021 оны хичээлийн жилийн сургалтын үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг хангах зорилгоор сургууль, цэцэрлэгийн удирдлагуудад сургалт явуулахдаа ” Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуй, орчны ариун цэвэр, халдвар хамгааллын дэглэм, журмыг мөрдөж ажиллах талаар БШУЯ, МХЕГ-аас өгсөн чиглэлийг танилцуулж ажилласан. Хоол үйлдвэрлэлийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд:

- Бүх сургууль, цэцэрлэгүүд мэргэжлийн байгууллагатай хамтран орчны халдваргүйжилт хийх
- Усны дээж шинжлүүлэх
- Тогооч, багш нарыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг 100% хийлгэж бэлтгэлийг хангасан.



Хичээлийн жил эхлээд удаагүй байхад Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлтэй холбоотой зөрчил дутагдал гарснаар, сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ ихээхэн анхаарал татаж, түүний мөрөөр зарим арга хэмжээг авч шийдвэрлээд байна. Тухайлбал:

1. Мандал сумын 3 дугаар сургууль дээр гарсан зөрчлийн дагуу :

- Хоол үйлдвэрлэлийн ачааллыг багасган үдийн цайг нийлүүлэх хуваарь, хоолны цэс, технологийн картыг шинэчлэн боловсруулсан
- Сургуулийн хогийн цэгийг хашаажуулж, 4 машин хуурай хог хаягдлыг ачуулж, 6 удаагийн давтамжаар 7 машин бохирын лагийг соруулсан
- Мөн Үдийн цайны хоол үйлдвэрлэлийн ажлын байрны бохир усны хоолойг төвийн шугамд холбох зураглал гаргаж, шаардагдах 3 сая төгрөгийн зардлыг төсвийн тодотголд тусгуулан, гал тогооны бохирын хоолойг холбох ажлыг мэргэжлийн хүмүүсээр хийлгэсэн
- Хоол үйлдвэрлэлийн технологийн шат дамжлагыг нэг чигийн урсгалтай байхаар өрөө тасалгаа гарган, хана таазны будаг шохой, агааржуулалтын системийг шинэчлэх, халуун цехийг битүүлэх, шалны модыг хэсэгчлэн солих, шалны хөндий хэсгийн зайд мэрэгч шавжийн хор цацах, махны машин, 1-р хоолны ремин, цахилгааны мантаж солих, эвдэрсэн тоног төхөөрөмжийг засварлах, гал тогооны хэрэгслийг шинэчлэх ажлуудыг шат дараатай хийж 790.000 төгрөг зарцуулсан.



- Хоолны цэсэнд тусгагдсан хоол, хүнсний түүхий эд, материалыг урьд өдөр болон долоо хоногийн өмнө бэлтгэж шаардлага хангахгүй агуулах, саванд хадгалдаг байсныг болиулж, тухайн өдөр нь шууд худалдан авч бэлтгэн нийлүүлж байх зохицуулалт хийсэн
- Сургуулийн дотоод хяналтын багийн журамд МХЕГ-ын даргын А/179 тоот тушаалаар батлагдсан “ Хоол, үйлдвэрлэл үйлчилгээний газарт мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм”-ийг тусгаж ажиллах чиглэл өгөн ажиллаж
- Хоол үйлдвэрлэлийн анхан шатны 11 төрлийн бүртгэл тэмдэглэлийг зааврын дагуу боловсруулан гаргаж үйл ажиллагаандаа ашиглахаар бэлтгэсэн
- Тухайн үед БШУЯ-ны Хоол үйлдвэрлэлийн хэлтэст хоолны хордлогот өвчлөлийн талаар өдөр тутам мэдээлж, тус сургуулийн гал тогоонд шаардлагатай тоног төхөөрөмжийн хүсэлтийг албан бичгээр өгч шийдвэрлүүлэн 8,9 сая төгрөгийн 7 төрлийн тоног төхөөрөмж нийлүүлэн үдийн цайны хоол үйлдвэрлэлийг хэвийн үргэлжлүүлээд байна.



2. ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10.2.8-д заасны дагуу тогоочийг бэлтгэх, давтан сургах бодлогыг тодорхойлж БШУЯ-аас сургуулийн тогооч нарыг чадваржуулах ажлыг эхлүүлэхийн зэрэгцээ бид зөвлөгөө мэдээллээр тасралтгүй ханган ажиллаж байна.
  - 2020 оны 10 дугаар сарын 26-аас эхлэн үе шаттай зохион байгуулж буй тэрхүү сургалтад манай аймгаас 15 тогооч хамрагдаж байгаа бөгөөд мөн дээрх 2 сургуулийн тогоочийг мөн хамруулсан.
  - Дээрх зөрчил дутагдал гарсантай холбогдон, эрсдэл үүсэж болзошгүй байдлыг харгалзан БСУГ- нь сургууль, цэцэрлэгийн удирдлага, тогооч, няравуудад онлайн хурал хийж, МХГ-ын байцаагч нарыг оролцуулан зөвлөгөө өгсөн.
  - МХЕГ-аас зохион байгуулсан “ Аж ахуйн нэгж байгууллагын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг хэрэгжүүлэх сургалтад сургууль цэцэрлэгийн дотоод хяналтын багийн 37 ажилтан, БСУГ-ын 3 мэргэжилтэн оролцож, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу сургууль, цэцэрлэгүүд дотоод хяналтын багийг томилж, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.
3. Мандал сумын 1 дүгээр сургууль нь хичээлийн 1-р байранд хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа 44,4м<sup>2</sup> талбай бүхий нэг ангид явуулдаг байсан бол 2020-2021 оны хичээлийн жил эхлээд бага сургуулийн хичээлийн байранд шилжүүлж талбайг томсгон 90.6м<sup>2</sup> талбай бүхий бохир, цэвэр усны шугамтай томоохон танхимыг дахин тохижуулж, бэлтгэлийн болоод угаалгын өрөө, хоол үйлдвэрлэлийн халуун цех, түүхий эд хүлээн авах өрөө, хоолны заал зэргийг тус тусд нь тохижуулж ашиглаж байна.
4. Мандал сумын Түнхэл тосгоны Ерөнхий боловсролын сургууль нь цайны газрын өргөтгөл хийлгэн ашиглалтад оруулж, ДЗОУБ-ын хөрөнгө оруулалтаар 9,9 сая төгрөгийн гал тогооны иж бүрэн тоног төхөөрөмж нийлүүлэгдэн ашиглаж эхлээд байна.

“Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай” хууль, “Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх явцад мэдээллээр ханган, зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулж байгаа хэдий ч, орчны эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангах, чанартай

хоол хүнсийг бэлтгэн нийлүүлэх, гал тогооны хэрэглэл, аяга тавгийг угааж ариутгах, үйлдвэрлэл явуулахад сургууль бүр харилцан адилгүй үйлчилгээ үзүүлж байна.

Иймд дахин эрсдэл гарахаас урьдчилан сэргийлэхийн тулд:

1. Ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн орчныг бий болгож сайжруулан, зориулалтын бус гал тогооны тоог бууруулж ашиглах
2. Чанартай, эрүүл аюулгүй хоол хүнсийг хүүхдэд нийлүүлэх
3. Сургуулийн ажиллагсдыг чадваржуулах, давтан сургах, мэргэжлийн хоол зүйчийг бэлтгэх ажлыг үе шаттай зохион байгуулах зорилт дэвшүүлэн тулгамдсан зарим асуудлыг шийдвэрлэхийн тулд дараах арга хэмжээ авч ажиллахыг санал болгож байна.

Үүнд:

1. Үдийн цайны хүнсний бүтээгдэхүүний түүхий эд материалыг урьдчилан бэлтгэж худалдан авдаг. Гэтэл худалдан авах төсвийн санхүүжилт сарын сүүлийн 10 хоногт ирдэг тул урьдчилж аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ хийх болдог. Энэхүү гэрээг хийх аж ахуйн нэгж байгууллагуудыг сонгон шалгаруулах төндэр зарлахад шаардлага хангах аж ахуйн нэгж байгууллага оролцдоггүй хүндрэл байна. Энэ асуудлыг судалж, зохицуулалт хийн шийдвэр гаргах
2. Зориулалтын бус гал тогоотой байгаа Алтанбулаг, Сүхбаатар сумын 4, Ерөө, Мандал 1, Мандал 2, Мандал 3, Хушаат, Шаамар сумын Дулаанхаан тосгоны сургуулийн гал тогоог шаардлага хангасан, зориулалтын болгох асуудлыг үе шаттай шийдвэрлэх
3. Сургууль дээр хүнсний түүхий эд материалыг хадгалах зориулалтын агуулахтай болгох асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх
4. Хүүхдэд нийлүүлж буй хоол, бэлэн бүтээгдэхүүний дээжийг шинжлүүлэхэд шаардлагатай төсвийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх
5. Сургууль, цэцэрлэг бүрийн гал тогоог кварцын гэрэлтэй болгох
6. Дараах сургуулиудад нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг шат дараалан шинэчлэх арга хэмжээ авах

№	Сургуулийн нэр	1-р хоолны тогоо	4 ширэм тэй цахилгаан зуух	Дээжний хөргөгч	Хөлдөөгч	Хөргөгч	Гурил зуурагч	Уур сорогч	Аяга таваг ариутгагч	Шарах шүүгээ	Цахилгаан том жигнүүр
1	Сүхбаатар -1		1	1	1		1				
2	Сүхбаатар - 4							1			
3	Баруунбүрэн					1					
4	Баянгол					1	1		1		
5	Бугант							1	1		
6	Мандал -1		1								
7	Мандал -2		1							1	
8	Мандал - 4		1	1							

9	Хэрх	1	1		1						
10	Орхон		1		1					1	
11	Орхонтуул - 1							1			
12	Сайхан - 1	1	1						1		1
13	Сайхан - 2	1			1	1					
14	Түшиг				1	1			1		
15	Хүдэр		1							1	1
16	Жавхлант										
17	Хушаат		1						1		
18	Дулаанхаан								1		
<b>Бүгд</b>		<b>3</b>	<b>9</b>	<b>2</b>	<b>5</b>	<b>4</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>6</b>	<b>3</b>	<b>2</b>

7. Сургууль, цэцэрлэгийг мэргэжлийн тогоочоор хангах, давтан бэлтгэх, хоол зүйчтэй болоход дэмжлэг үзүүлж, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах
8. Мэргэжлийн зэргийн нэмэгдэл авдаггүй тогооч нарт зэргийн нэмэгдлийг нь олгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, зэрэггүй тогооч нарын ур чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх
9. Сургууль, цэцэрлэгийн дотоод хяналтын багийн үйл ажиллагааг дэмжин чанаржуулах, хариуцлагатай ажиллах боломжийг бүрдүүлэх
10. Угаагч, тогоочийн орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай сургуулийн асуудлыг шийдвэрлэх /Сайхан-1, Мандал-3, Сүхбаатар -3, Орхонтуул-2 дугаар сургууль/ шаардлагатай байгааг Аймгийн Засаг даргад албан бичгээр хүргэж дараах ажлуудыг хамтран зохион байгуулж хэрэгжүүлэхээр санал болгосон.

Хамтран зохион байгуулах ажлын санал:

1. Сургуулийн Үдийн цай, Дотуур байрны туслах тогооч нарын сургалтыг МСҮТөвтэй хамтран зохион байгуулж гэрчилгээжүүлэх
2. Холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажилгүй байгаа мэргэжлийн хоол зүйчдийн судалгаа гаргаж, суманд хоол зүйчийн орон тоо бий болгох
3. Сумдын цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэлийн нөхцөл байдалд үнэлгээ дүгнэлт өгч, зөвлөн туслах мэргэжлийн байгууллагын хамтарсан баг томилж ажиллуулах
4. Мэргэжлийн байгууллагатай хамтран сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтан, тогооч, нярав, угаагч нарыг оролцуулсан сургалт зөвлөгөөн зохион байгуулах

Боловсруулсан: Мэргэжилтэн

П.Мягмарсүрэн